

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2024 оны 8 сарын 29-ний өдөр;

Хурлын байршил: Цахимаар

Хурал эхэлсэн цаг: 11:00 цаг;

Хурлын дарга: “Ард Кредит ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (Цаашид “ТУЗ” гэх)-ийн дарга Ч.Ганзориг;

Хуралд оролцсон удирдлагын багийн гишүүн: Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар, Санхүү Эрхэлсэн Захирал Д.Лхагва-Очир, Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуримтлагдсан ашгаас нэмэгдүүлэх;
2. “Ард Кредит ББСБ” ХК-ийн компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - a. Компанийн хаягийг өөрчлөх;
 - b. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2 ердийн гишүүдийг томилох;

Хурал нээх: Хурлын дарга Ч.Ганзориг

“Ард Кредит ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсний дагуу энэхүү хуралдаанаа цахимаар хийж байна. Хурлын ирцийг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлийг урьж байна.

Хурлын ирц: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

“Ард Кредит ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 24/04 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, “Ард Кредит ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Ард Кредит ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 297,527,428 ширхэг буюу 82.47 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцож байна. Компанийн **тухай хуулийн** 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны **82.47** хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөр **болно**.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын ирцтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

Хурлын дэг: Хурлын дарга Ч.Ганзориг

Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. Хуримтлагдсан ашгаас компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх талаарх асуудлыг Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир, Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах өөрчлөлтийг гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар, миний бие ТУЗ-ийн Ердийн гишүүнд нэр дэвшигч нарыг тус тус танилцуулна. Өнөөдрийн хуралд компанийн удирдлагын багийн төлөөлөл цахимаар оролцож байна. Хувьцаа эзэмшигч та бүхэн асуулт асууж,

саналаа хэлэх боломжтой. Дээрх 3 асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигч та саналаа Ард аппаар өгөх боломжтой. Санал хураалтын дүнг нэгтгээд, тогтоолын төслүүдээ та бүхэндээ танилцуулаад батлуулаад хурлаа хаана. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нь амжилт хүсье. Хэлэлцэх асуудлын дагуу Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очирыг танилцуулгаа хийхийг урьж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын дэгт холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуримтлагдсан ашгаас нэмэгдүүлэх

Танилцуулга хийсэн Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир:

Сайн байцгаана уу, эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. “Ард Кредит ББСБ” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Д.Лхагва-Очир миний бие Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлын талаар танилцуулах болно. Итгэлцлийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагын хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2026 он гэхэд 5 тэрбум дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болох шаардлагатай болсон.

“Ард Кредит ББСБ” ХК-ийн хувьд эхний хагас жилд FPO буюу энгийн хувьцаа гаргаж, 3,640,000,000.00 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсон. Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагыг хангахын тулд дор хаяж 5 тэрбум хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болох шаардлагатай. Бид хагас жилийн үйл ажиллагааны тайланг компанийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар шууд дамжуулж, компанийн нийт хөрөнгө 83.7 тэрбум төгрөг, түүнээс эздийн өмч 28.7 тэрбум төгрөг болсон. Мөн бусдаас татан төвлөрүүлдэг хөрөнгө 27.1 тэрбум төгрөг болж, хагас жилийн байдлаар 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн зохицуулалтын тухайд Компанийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дүрэм журмын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувь иргэний хувьд татвар суутгасны дараах орлого, аж ахуй нэгжийн хувьд аудитлагдсан тайлан дээрх хуримтлагдсан ашиг болон хөрөнгө борлуулсны орлого байна гэж заасны дагуу хуримтлагдсан ашгаас ногдол ашиг зарлаж, татвар суутгах байдлаар нэмэгдүүлэх талаар ТУЗ-д танилцуулж, зөвшөөрөгдсөн. Одоо 10 төгрөгний нэрлэсэн үнэтэй 360,000 хувьцаатай байгааг 4 төгрөгөөр нэмэгдүүлж, түүнээсээ татвараа хассанаар 13.8 төгрөг болгон нэмэгдүүлснээр 5 тэрбум 23 сая болж шаардлага хангах юм. Хуримтлагдсан ашгийн хувьд эхний хагас жилийн байдлаар 9.8 тэрбум төгрөг, үүнээс татвараа хасаад 8.4 тэрбум төгрөг болно. Үүнтэй холбоотой асууж тодруулах зүйл байвал асууж болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид Хуримтлагдсан ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан санал гаргаагүй болно.

Хурлын дарга Ч.Ганзориг: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах талаар Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар танилцуулна уу.

2. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Компанийн дүрэмд нэгдүгээрт, Манай байгууллага өмнө нь Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр барилгын 13 давхар, 1313 тоотод үйл ажиллагаа явуулж байсан. Харин одоо тус барилгын 17 давхарт үйл ажиллагаа явуулж байгаа тул компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд оруулж, холбогдох байгууллагуудад мэдэгдэх, бүртгүүлэх шаардлагатай. Үүний тулд Компанийн дүрмийн 1.7 дахь хэсэгт Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал

тауэр барилгын 17 давхар. Утас: (+976) 77003322, info@ardcredit.com, www.ardcredit.com гэж оруулах шаардлагатай.

Хоёрдугаарт, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан Компанийн дүрмийн 6.1 дэх хэсэгт Компанийн нэг бүр нь 13.8 (арван гурав аравны найм) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,023,200,000 (таван тэрбум хорин гурван сая хоёр зуун мянга) ширхэг хувьцаатай байна, 6.2 дахь хэсэгт Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 5,023,200,000 (таван тэрбум хорин гурван сая хоёр зуун мянга) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрднэ гэж тус тус оруулах саналтай байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн дүрмийг батлахтай холбогдуулан санал гаргаагүй болно.

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн 2 гишүүнийг томилох

Хурлын дарга Ч.Ганзориг: ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийг томилох танилцуулгыг хийе.

Гурван нэр дэвшигчид байгаа эхнээс нь эхлээд танилцуулаад явъя. Хувьцаа эзэмшигчид та бүхэн Г.Сүхбаатар захирлыг таньж байгаа байх. Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар нь нягтлан бодох бүртгэл, Санхүүгийн удирдлага мэргэжилтэй. Ард Кредит ББСБ ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Эзэмшиж буй хувьцааны хэмжээ 236,931 ширхэг.

Дараагийн нэр дэвшигч бол Ө.Ашхүү. Эрх зүйч, хуульч мэргэжилтэй. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Комплаенс эрхэлсэн захирлаар ажиллаж байгаа. Эзэмшиж буй хувьцааны хэмжээ 3,620.

Сүүлийн нэр дэвшигч бол М.Мөнх-Эрдэнэ. Банкны эдийн засаг, нягтлан бодох бүртгэл мэргэжилтэй. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Аудит эрхэлсэн захирлаар ажилладаг. Эзэмшиж буй хувьцааны хэмжээ 174,726. Эдгээр хүмүүс ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшиж байна. Хоёр гишүүн сонгоно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн 2 гишүүнийг томилохтой холбогдуулан санал гаргаагүй болно.

Хурлын дарга Ч.Ганзориг: Хурлын танилцуулах хэсэг дууслаа. Одоо асуулт, хариултын цаг эхэлж байна.

4. Хэлэлцэх асуудалтай холбоотой, асуулт хариулт

Хувьцаа эзэмшигчдийн тавьсан асуултад Хурлын дарга Ч.Ганзориг болон бусад албан тушаалтнууд зохих хариуг өгсөн болно. Санал гараагүй болно.

5. Саналын хураалтын дүнг нэгтгэх, танилцуулах

Тооллогын комисс Ө.Бямбагэрэл:

Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтыг нэгтгэн танилцуулахад бэлэн болоод байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон Ард Аппаар ирүүлсэн саналын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ нь:**

Хурлаар хэлэлцсэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухайд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 297,527,428 ширхэг буюу 82.47 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд 297,527,428 ширхэг санал ирснээс 297,527,428 ширхэг буюу 100 хувь зөвшөөрсөн санал өгч дэмжигдлээ. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.

Хурлаар хэлэлцсэн Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг батлах тухайд хуралд оролцсон 297,527,428 хувьцаа эзэмшигчдээс 297,527,428 санал буюу 100 хувийн зөвшөөрсөн саналаар тус тус дэмжигдлээ. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.

Хурлаар хэлэлцсэн ТУЗ-ийн гишүүнийг томилох тухайд хуралд оролцсон 297,527,428 хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшигч Г.Сүхбаатарт 297,527,428 санал буюу 100 хувийн зөвшөөрсөн, нэр дэвшигч Ө.Ашхүүд 28,723,737 санал буюу 9.65 хувийн зөвшөөрсөн, нэр дэвшигч М.Мөнх-Эрдэнэд 268,803,691 ширхэг буюу 90.35 хувийн зөвшөөрсөн саналаар тус тус дэмжигдлээ. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй. Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг тус тус батлан шийдвэрлэлээ.

Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, энэхүү хурлын хаана уу хэмээн “Ард Кредит ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганзориг танийг урьж байна.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр 1:

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 8 сарын 29-ний өдрийн Тооллогын комиссын 24/05 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнийг 10 /арав/ төгрөг байсанг 13.8 /арван гурав төгрөг найман мөнгө/ төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 364,000,000 /гурван зуун жаран дөрвөн сая/ хувьцаанаас бүрдэх 3,640,000,000 /гурван тэрбум зургаан зуун дөчин сая/ төгрөг байсанг Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 13.8 /арван гурав төгрөг найман мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 364,000,000 /гурван зуун жаран дөрвөн сая/ хувьцаанаас бүрдэх 5,023,200,000 (таван тэрбум хорин гурван сая хоёр зуун мянга) төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэлийн өдрөөр тооцон, Компанийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон зохицуулагч байгууллагаас баталсан журамд нийцүүлэн хуримтлагдсан ашгаас холбогдох татварыг суутган хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Сүхбаатар/-т үүрэг болгосугай.
4. Компанийн дүрэмд энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан агуулгаар өөрчлөлт оруулж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Сүхбаатар/-т даалгасугай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр 2:

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 30 дүгээр зүйлийн 30.5 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 8 сарын 29-ний өдрийн Тооллогын комиссын 24/06 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Компанийн дүрмийн 1.7 дахь хэсэгт “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр барилгын 17 давхар” гэж;
 - 1.2. Компанийн дүрмийн 6.1 дэх хэсэгт “Компанийн нэг бүр нь 13.8 /арван гурав төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна.” гэж;

1.3. Компанийн дүрмийн 6.2 дахь хэсэгт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 5,023,200,000 (таван тэрбум хорин гурван сая хоёр зуун мянга) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.” гэж тус тус өөрчлөх;

2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Сүхбаатар/-т даалгасугай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр 3:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 8 сарын 29-ний өдрийн Тооллогын комиссын 24/07 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүдээр дараах нэр дэвшигчийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаанд томилсугай.

1.1. Гүррагчаа овогтой Сүхбаатар;

1.2. Мөнхбат овогтой Мөнх-Эрдэнэ.

2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлж зохих зөвшөөрөл, дүгнэлтийг гаргуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Г.Есү-Үжин/-д даалгасугай.

Өнөөдрийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурал өндөрлөж, хурлыг хааж байна.
Хурал 12 цаг 10 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА:

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Ч.ГАНЗОРИГ

Г.ЕСҮ-ҮЖИН